



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Далай ашиглах тухай” /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, үзэл баримтлал, “Усан замын тээврийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах “Ажлын хэсэг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Мэргэн

Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Б.Мөнхболд

Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Д.Жавхлан

Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн

Л.Булганхүү

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн

Т.Уянга

Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

А.Энхжаргал

Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Д.Ганбаатар

Зам, тээврийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн

С.Түвшинтөр


Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Энхбаатар	Далайн захиргааны дарга
Д.Байгалмаа	Далайн захиргааны ахлах мэргэжилтэн
Г.Золбоо	Далайн захиргааны мэргэжилтэн
Б.Оргил	Далайн захиргааны мэргэжилтэн
Э.Мягмардорж	Оюуны өмчийн газар, Аж үйлдвэрийн өмч, Зохиогчийн эрхийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/

2. “Далай ашиглах тухай” /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, үзэл баримтлал, “Усан замын тээврийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, 2015 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Р.Мэргэн/-д үүрэг болгосугай.

3. “Далай ашиглах тухай” /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, үзэл баримтлал, “Усан замын тээврийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулахтай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу санхүүжүүлэхийг Далайн захиргаа /Х.Энхбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2012 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Зам, тээврийн сайдын 25 дугаар тушаал /Ажлын хэсэг байгуулах тухай/ болон 2014 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн Зам, тээврийн сайдын 38 дугаар тушаал / Ажлын хэсэг байгуулах тухай /-ыг тус тус хүчингүй болгосугай.





ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2010 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дугаар заалт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын зөвлөлийн 2010 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Н.Нямдаваа /Зам, тээврийн бодлогын газрын орлогч дарга/

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Д.Ганбаатар /Далайн захиргааны ажилтан/

Гишүүд: Д.Галсандондог /Далайн захиргааны дарга/

Ж.Жамбажамц /Далайн захиргааны орлогч дарга/

Д.Баярхүү /Төрийн захиргааны удирдлагын газрын орлогч дарга, Хуулийн зөвлөх/

Б.Мөнхболд /Зам, тээврийн бодлогын газрын мэргэжилтэн/

А.Энхболд /Зам, тээврийн бодлогын газрын мэргэжилтэн/

Б.Жавсан /Далайн нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн/


2. “Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, 2010 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх

08 00687

бэлтгэл ажлыг хангах, хууль батлагдсантай холбогдуулан гарах дүрэм, журмыг боловсруулан батлуулах бэлтгэл ажлыг хангахыг Ажлын хэсэг /Н.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. “Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулахтай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу санхүүжүүлэхийг Далайн захиргаа /Д.Галсандондог/-нд зөвшөөрсүгэй.

САЙД



Х.БАТТУЛГА